



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/128/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг
Сайншанд сум
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас:70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цахмал хууцаг: dornogovi@audit.gov.mn

2023.03.24 № 1-6/244

танай _____ -ны № _____ -т

ЭРДЭНЭ СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
С.ЦЭЦЭГСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзлээ.

Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж, эрүүл мэндийн байгууллагуудын даатгалын сангаас төлөх зардлын төлбөрийг тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр тооцож, 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгох болсон байна.

Илрүүлэлтээр шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 952.9 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 827.2 сая төгрөгийн 30 гүйлгээ, 9.3 сая төгрөгийн 6 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 114.9 сая төгрөгийн орлогын 4 гүйлгээ, төсөв,

өмч, хөрөнгө зарцуулах 1.5 сая төгрөгийн 3 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцээгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 14 харилцагчдаас 13.8 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 1.0 сая төгрөгөөр дутуу байгуулсан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйл "Нягтлан бодох бүртгэл хөтлөх"-ийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:, 14.4.6.бүх зардал; 14.4.7.нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс" гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Тайлант хугацааны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийгдэж буй аудитад шаардсан материалуудыг тогтоосон цаг хугацаанд бүрэн гүйцэт гаргаж ирүүлээгүй, аудитын шалгалтын ажилд хүндрэл саад учруулсан бөгөөд энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйл "16.1.1.төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах; 16.1.3.төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, оролцохгүй байх; 16.1.4.төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх; 16.1.6.хуульд заасан бусад үүрэг." заалтуудтай нийцээгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 8 зорилт, 95 арга хэмжээний хэрэгжилт 98.5 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 71.7 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т. ГАН-ӨЛЗИЙ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	263,363,433.32	348,844,368.26
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,454,561.37	188,228,626.23
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,454,561.37	188,228,626.23
3121	Төгрөг	3,454,561.37	188,228,626.23
31211	Төрийн сангийн харилцах	3,324,931.62	188,228,626.23
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	129,629.75	-
33	АВЛАГА	135,376,411.00	10,164,120.00
335	Бусад авлага	135,376,411.00	10,164,120.00
3351	Байгууллагаас авах авлага	135,376,411.00	10,164,120.00
35	БАРАА МАТЕРИАЛ	124,532,460.95	150,451,622.03
351	Түүхий эд материал	77,758,436.79	94,452,750.20
35110	Тусгай зориулалттай материал	27,699,246.07	29,053,202.06
35130	Эм боох материал	50,059,190.72	65,399,548.14
354	Хангамжийн материал	46,774,024.16	55,998,871.83
35410	Бичиг хэргийн материал	4,994,311.00	4,782,785.00
35420	Аж ахуйн материал	4,487,167.66	4,665,559.83
35430	Сэлбэг хэрэгсэл	1,530,000.00	929,200.00
35440	Түлш, шатах тослох материал	564,800.00	2,867,360.00
35450	Барилгын засварын материал	40,000.00	4,000,000.00
35460	Хүнсний материал	1,551,082.50	1,647,202.00
35470	Бусад хангамжийн материал	33,606,663.00	37,106,765.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	210,945,752.85	736,366,651.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	210,945,752.85	736,366,651.01
392	Биет хөрөнгө	188,936,336.05	714,842,984.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	49,736,620.00	572,190,127.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(19,770,291.36)	(35,067,946.92)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	92,536,434.00	92,536,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(31,496,492.27)	(42,032,564.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	107,893,754.56	101,495,405.85
39206	Хуримтлагдсан элэгдэл	(63,767,212.71)	(35,880,554.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,876,628.15	34,888,722.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,471,913.94)	(9,977,492.77)
39214	Бусад үндсэн хөрөнгө	45,870,658.00	45,870,658.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,678,296.38)	(9,386,252.30)
39217	Ном	206,448.00	206,448.00
393	Биет бус хөрөнгө	22,009,416.80	21,523,666.88
39301	Програм хангамж	2,382,000.00	2,382,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,296,583.20)	(1,782,333.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,924,000.00	20,924,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	474,309,186.17	1,085,211,019.27
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	36,403,683.43	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	36,403,683.43	-
413	Өглөг	36,403,683.43	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	17,809,278.53	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	18,346,335.90	-
4136	Бусад өглөг	248,069.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	248,069.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	437,905,502.74	1,085,211,019.27
51	Засгийн газрын хувь оролцоо	437,905,502.74	1,085,211,019.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	205,923,538.50	205,923,538.50
51101	Өмч: - төрийн	205,923,538.50	205,923,538.50
512	Хуримтлагдсан үр дүн	228,660,554.24	875,966,070.77
51210	Өмнөх үеийн үр дүн	228,660,554.24	228,660,554.24
51220	Тайлант үеийн үр дүн	-	647,305,516.53
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,321,410.00	3,321,410.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	474,309,186.17	1,085,211,019.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	470,055,058.81	1,253,712,294.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	611,809,133.21

120	Нийтлэг татварын бус орлого	-	611,809,133.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	592,383,983.21
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		120,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		592,263,983.21
120009	Бусад орлого	-	19,425,150.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	470,055,058.81	641,903,160.88
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	367,460,700.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367,460,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,521,631.59	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	49,521,631.59	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,406,697.22	59,448,110.88
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,406,697.22	59,448,110.88
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	19,666,030.00	582,455,050.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,666,030.00	582,455,050.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	745,140,152.05	606,406,777.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	745,140,152.05	606,406,777.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	725,740,152.05	606,406,777.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	294,007,990.48	289,720,916.70
210101	Үндсэн цалин	202,584,888.28	212,410,381.02
210102	Нэмэгдэл	58,284,329.70	58,771,739.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,483,000.00	3,761,000.00
210104	Урамшуулал	26,655,772.50	14,777,796.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,733,932.95	35,344,407.80
210201	Тэтгэврийн даатгал	25,653,239.83	25,461,526.98
210202	Тэтгэмжийн даатгал	2,680,300.00	2,985,090.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,144,200.00	2,213,352.60
210204	Ажилгүйдлийн даатгал	536,100.00	425,857.87
210205	Эрүүл мэндийн даатгал	8,720,093.12	4,258,579.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,762,599.62	49,484,460.88
210301	Гэрэл, цахилгаан	2,650,299.62	3,041,805.88
210302	Түлш, халаалт	27,119,400.00	44,923,460.00
210303	Цэвэр, бохир ус	1,992,900.00	1,519,195.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,262,525.18	36,484,843.14
210401	Бичиг хэрэг	1,824,690.00	4,854,826.00
210402	Тээвэр, шатахуун	24,232,070.00	24,577,595.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,184,225.80	1,263,285.71
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	710,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,541,539.38	5,079,136.43
2105	Нормативт зардал	280,677,135.27	124,553,894.91
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	266,801,844.67	112,390,319.41
210502	Хоол, хүнс	13,875,290.60	8,579,305.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	3,584,270.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,351,700.00	15,258,472.79
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,841,800.00	4,447,706.11
210602	Тавилга	-	334,516.68
210604	Урсгал засвар	1,509,900.00	10,476,250.00
2107	Томилолт, зочны зардал	353,500.00	2,350,000.00
210702	Дотоод албан томилолт	353,500.00	2,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,026,295.98	2,420,763.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,996,006.98	480,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	270,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	594,450.00	1,486,075.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,110.00	124,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	43,000.00	43,000.00
210807	Газрын төлбөр	21,729.00	17,688.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,564,472.57	50,789,018.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,325,000.00	1,274,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,239,472.57	49,514,318.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,400,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,400,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,400,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(275,085,093.24)	647,305,516.53
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	496,989.08	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	496,989.08	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(496,989.08)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(275,582,082.32)	647,305,516.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	473,085,637.81	767,235,451.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	135,496,411.00
	Нийтлэг татварын бус орлого	-	135,496,411.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	135,496,411.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		135,376,411.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		120,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	473,085,637.81	631,739,040.88
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	367,460,700.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367,460,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,304,141.59	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	52,304,141.59	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	33,406,697.22	59,448,110.88
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	33,406,697.22	59,448,110.88
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	19,914,099.00	572,290,930.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	19,914,099.00	572,290,930.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	499,581,225.44	559,629,387.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	499,581,225.44	559,629,387.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	472,181,225.44	559,629,387.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,485,146.95	303,841,371.44
210101	Үндсэн цалин	185,062,044.75	177,479,821.57
210102	Нэмэгдэл	58,284,329.70	107,202,979.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,483,000.00	4,473,999.57
210104	Урамшуулал	26,655,772.50	14,684,570.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,787,946.83	39,281,300.59
210201	Тэтгэврийн даатгал	22,066,846.83	27,469,178.35
210202	Тэтгэмжийн даатгал	2,680,300.00	3,128,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,144,200.00	2,402,633.10
210204	Ажилгүйдлийн даатгал	536,100.00	488,742.68
210205	Эрүүл мэндийн даатгал	5,360,500.00	5,792,346.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,762,599.62	49,484,460.88
210301	Гэрэл, цахилгаан	2,650,299.62	3,041,805.88
210302	Түлш, халаалт	27,119,400.00	44,923,460.00
210303	Цэвэр, бохир ус	1,992,900.00	1,519,195.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,628,230.80	35,173,410.71
210401	Бичиг хэрэг	3,553,900.00	4,567,700.00
210402	Тээвэр, шатахуун	17,575,950.00	26,167,625.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,158,125.80	1,268,285.71
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	873,000.00	710,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,467,255.00	2,459,800.00
2105	Нормативт зардал	67,589,785.37	96,785,645.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,705,515.37	83,702,313.40
210502	Хоол, хүнс	10,384,270.00	9,827,332.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,500,000.00	3,256,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,202,339.00	24,333,830.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,066,410.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,222,500.00	5,053,600.00
210604	Урсгал засвар	7,913,429.00	19,280,230.00
2107	Томилолт, зочны зардал	353,500.00	2,350,000.00
210702	Дотоод албан томилолт	353,500.00	2,350,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,314,088.87	4,705,783.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,283,799.87	2,792,020.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	270,000.00	270,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	594,450.00	1,486,075.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,110.00	97,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	43,000.00	43,000.00
210807	Газрын төлбөр	21,729.00	17,688.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,057,588.00	3,673,585.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,057,588.00	3,673,585.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,400,000.00	-

2132	Бусад урсгал шилжүүлэг	27,400,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	27,400,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(26,495,587.63)	207,606,064.86
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	13,640,940.00	22,832,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,640,940.00	22,832,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,640,940.00	22,832,000.00
222001	Тоног төхөөрөмж	2,189,000.00	13,634,000.00
223001	Бусад хөрөнгө	11,451,940.00	9,198,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(13,640,940.00)	(22,832,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(40,136,527.63)	184,774,064.86
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,454,561.37
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,454,561.37	188,228,626.23

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,923,538.50	3,321,410.00	228,660,554.24	437,905,502.74
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	205,923,538.50	3,321,410.00	228,660,554.24	437,905,502.74
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	205,923,538.50	3,321,410.00	228,660,554.24	437,905,502.74
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	647,305,516.53	647,305,516.53
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	205,923,538.50	3,321,410.00	875,966,070.77	1,085,211,019.27

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	812,542,700.00	582,461,387.02	230,081,312.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	812,542,700.00	559,629,387.02	252,913,312.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	812,542,700.00	559,629,387.02	252,913,312.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	347,429,900.00	303,841,371.44	43,588,528.56
210101	Үндсэн цалин	188,367,700.00	177,479,821.57	10,887,878.43
210102	Нэмэгдэл	137,586,600.00	107,202,979.73	30,383,620.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,742,400.00	4,473,999.57	2,268,400.43
210104	Урамшуулал	14,733,200.00	14,684,570.57	48,629.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,749,700.00	39,281,300.59	2,468,399.41
210201	Тэтгэврийн даатгал	29,335,800.00	27,469,178.35	1,866,621.65
210202	Тэтгэмжийн даатгал	3,128,400.00	3,128,400.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,622,800.00	2,402,633.10	220,166.90
210204	Ажилгүйдлийн даатгал	605,700.00	488,742.68	116,957.32
210205	Эрүүл мэндийн даатгал	6,057,000.00	5,792,346.46	264,653.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,868,900.00	49,484,460.88	41,384,439.12
210301	Гэрэл, цахилгаан	5,500,000.00	3,041,805.88	2,458,194.12
210302	Түлш, халаалт	75,368,900.00	44,923,460.00	30,445,440.00
210303	Цэвэр, бохир ус	10,000,000.00	1,519,195.00	8,480,805.00
2104	Хангамж, бараа материалын зардал	78,333,000.00	35,173,410.71	43,159,589.29
210401	Бичиг хэрэг	7,140,600.00	4,567,700.00	2,572,900.00
210402	Тээвэр, шатахуун	64,598,400.00	26,167,625.00	38,430,775.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,094,000.00	1,268,285.71	825,714.29
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	710,000.00	790,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	2,459,800.00	540,200.00

2105	Нормативт зардал	161,824,100.00	96,785,645.40	65,038,454.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	139,063,300.00	83,702,313.40	55,360,986.60
210502	Хоол, хүнс	14,960,800.00	9,827,332.00	5,133,468.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,800,000.00	3,256,000.00	4,544,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,747,200.00	24,333,830.00	44,413,370.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,666,700.00	-	13,666,700.00
210602	Тавилга	19,666,700.00	-	19,666,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,000,000.00	5,053,600.00	1,946,400.00
210604	Урсгал засвар	28,413,800.00	19,280,230.00	9,133,570.00
2107	Томилолт, зочны зардал	2,500,000.00	2,350,000.00	150,000.00
210702	Дотоод албан томилолт	2,500,000.00	2,350,000.00	150,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,322,900.00	4,705,783.00	4,617,117.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,283,800.00	2,792,020.00	4,491,780.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	278,000.00	270,000.00	8,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,594,500.00	1,486,075.00	108,425.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,800.00	97,000.00	4,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	43,000.00	43,000.00	-
210807	Газрын төлбөр	21,800.00	17,688.00	4,112.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,767,000.00	3,673,585.00	8,093,415.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,767,000.00	3,673,585.00	8,093,415.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	22,832,000.00	(22,832,000.00)
2200	Дотоод эх үүсвэрээр	-	22,832,000.00	(22,832,000.00)
222001	Тоног төхөөрөмж	-	13,634,000.00	(13,634,000.00)
223001	Бусад хөрөнгө	-	9,198,000.00	(9,198,000.00)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	812,542,700.00	767,235,451.88	45,307,248.12
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	105,868,900.00	59,448,110.88	46,420,789.12
132001	Орон нутгийн төсвөөс	105,868,900.00	59,448,110.88	46,420,789.12
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	706,673,800.00	707,667,341.00	(993,541.00)
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	706,673,800.00	707,667,341.00	(993,541.00)
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	120,000.00	(120,000.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	120,000.00	(120,000.00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,454,561.37	(3,454,561.37)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		188,228,626.23	(188,228,626.23)
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22.00	22.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00	-
620003	Үйлчлэх ажилтан	6.00	6.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	135,506,040.75
213305	Нэмэлтийн дансны үлдэгдэл төвлөрүүлэх шилжүүлэг		135,506,040.75
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	135,376,411.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	135,376,411.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		135,376,411.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	129,629.75

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 146.9 сая төгрөгийн 4 алдаа¹ илэрснээс аудитын явцад 146.9 сая төгрөгийн 4 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Цалингийн зардалд 0.4 сая төгрөгийн эмийн зардал бүртгэснийг;
2. Ажилтанд олгох ХЧТА тэтгэмж 0.9 сая төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэснийг;
3. Эрүүл мэндийн даатгалаас авах нэг иргэний нормативт санхүүжилтийн 11,12-р сарын 20% болох 10.2 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй байсныг;
4. Мөнгөөр төлөгдсөн оны эхний 135.4 сая төгрөгийн авлагыг мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаагүй байсныг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 3 зөрчил² илэрснээс, 1 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 952.9 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 827.2 сая төгрөгийн 30 гүйлгээ, 9.3 сая төгрөгийн 6 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 114.9 сая төгрөгийн орлогын 4 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 1.5 сая төгрөгийн 3 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй байна.

2. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Анхан шатны баримтын тулгалтаар 14 харилцагчдаас 13.8 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”; 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 1.0 сая төгрөгөөр дутуу байгуулсан байна. Хөрөнгийн үлдэгдэл өртөг бодитоор илэрхийлэгдэхгүй байх үр дагавартай.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйл “Нягтлан бодох бүртгэл хөтлөх”-ийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:, 14.4.6.бүх зардал; 14.4.7.нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс” гэсэн заалтуудтай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлийн зардлыг бодитой бүртгэж, хөрөнгийн үлдэгдлийг үнэн зөвөөр илэрхийлж тайлагнах.

Дээрх албан шаардлагын биелэлтүүдийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардалд 0.4 сая төгрөгийн эмийн зардал бүртгэсэн.	1	389.6	0	-	1	389.6	1	389.6	0	-		
Ажилтанд олгох ХЧТА тэтгэмж 0.9 сая төгрөгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн.	1	939.2	0	-	1	939.2	1	939.2	0	-		
Эрүүл мэндийн даатгалаас авах нэг иргэний нормативт санхүүжилтийн 11,12-р сарын 20% болох 10.2 сая төгрөгийг авлагаар бүртгээгүй.	1	10,164.1	0	-	1	10,164.1	1	10,164.1	0	-		
Мөнгөөр төлөгдсөн оны эхний 135.4 сая төгрөгийн авлагыг мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаагүй.	1	135,376.4	0	-	1	135,376.4	1	135,376.4	0	-		
Дүн	4	146,869.3	-	-	4	146,869.3	4	146,869.3	-	-		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Анхан шатны баримтын тулгалтаар 14 харилцагчдаас 13.8 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна.	1				1								
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 1.0 сая төгрөгөөр дутуу байгуулсан байна.	1	1,037.9					1	1,037.9					
Дүн	2	1,037.9			1		1	1,037.9					-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 952.9 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 827.2 сая төгрөгийн 30 гүйлгээ, 9.3 сая төгрөгийн 6 шийдвэрийг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 114.9 сая төгрөгийн орлогын 4 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 1.5 сая төгрөгийн 3 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.	1		-		-		1		-
Дүн	1		-		-		1		-